



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагын хувь
нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Хорооны 2016 оны 271 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хавсралтад заасан хуваарийн дагуу нэмэгдүүлэхийг банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн
24 дүгээр тогтоолын хавсралт

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙ
НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ

Огноо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /сая төгрөгөөр/
2018.02.10	1,000.0
2019.02.10	1,400.0
2020.02.10	1,900.0
2021.02.10	2,500.0